



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 1/2017

Мандалговь

Г Хуулийн хэрэгжилтийг хангах тухай 7

Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1, 96.1.1, 96.1.2, 96.1.3 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль явагдаж байгаатай холбогдуулан 2017 оны 07 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, соёл урлаг, үзвэр, спортын олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллуулахыг хориглосугай.

Хоёр. Захирамжийн хэрэгжилтийг ханган, тухайн өдрүүдэд архи согтууруулах ундаагаар үйлчилж, худалдан борлуулахгүй байхыг нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий нийт аж ахуйн нэгжийн удирдлагуудад даалгасугай.

Гурав. Сонгуулийн үеэр олон нийтийн хэв журмыг чанд сахиулан, гэмт хэрэг зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, ард иргэдийн амгалан тайван, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Б.Очирдорж/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200675